



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2024/108/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2024 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

*Алхуу О.О.* № *77*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 6 сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд, ерөнхий боловсролын сургуулиудад сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх чиглэлийн хүрээнд цахим дижитал ангийг Боловсролын ерөнхий газрын санхүүжилтээр тайлант онд нээн ажиллуулсан байна.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургуулийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нийт төсвийн гүйцэтгэл 89.47 хувийн биелэлттэй байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн Газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240, 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоож, Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/109 тоот тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшуулалд нийт багш, ажилчдыг хамруулан олгохоор шийдвэрлэсэн байна

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.8 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>88,846,745.04</b>	<b>318,851,119.34</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>28,742,217.00</b>	<b>254,469,145.10</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>28,742,217.00</b>	<b>254,469,145.10</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>28,742,217.00</b>	<b>254,469,145.10</b>
31211	Төрийн сангийн харилцах	28,742,217.00	254,469,145.10
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,104,528.04</b>	<b>64,381,974.24</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,653,400.00</b>	<b>1,323,130.00</b>
35130	Эм боох материал	1,653,400.00	1,323,130.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>58,451,128.04</b>	<b>63,058,844.24</b>
35410	Бичиг хэргийн материал	1,935,100.00	3,227,100.00
35420	Аж ахуйн материал	7,802,346.18	8,768,706.18
35470	Бусад хангамжийн материал	48,713,681.86	51,063,038.06
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,452,014,763.01</b>	<b>3,679,603,257.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,452,014,763.01</b>	<b>3,679,603,257.91</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,634,614,763.01</b>	<b>2,863,578,257.87</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,534,911,736.48	2,534,911,736.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(315,542,117.34)	(393,122,515.38)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	190,190,225.00	428,995,779.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,216,060.88)	(98,785,022.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,165,254.28	275,997,773.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,334,705.12)	(58,847,537.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	187,269,454.84	196,250,745.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(47,589,434.44)	(65,224,566.52)
39217	Ном	40,760,410.19	43,401,864.43
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>817,400,000.00</b>	<b>816,025,000.04</b>
39301	Програм хангамж	13,243,936.00	13,243,936.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,743,936.00)	(9,118,935.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	811,900,000.00	811,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,540,861,508.05</b>	<b>3,998,454,377.25</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,540,861,508.05</b>	<b>3,998,454,377.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,540,861,508.05</b>	<b>3,998,454,377.25</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,543,556,279.24	1,543,556,279.24
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,543,556,279.24	1,543,556,279.24
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(918,438,564.92)</b>	<b>(460,845,695.72)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,459,300,072.97)	(918,438,564.92)
51220	Тайлант үеийн үр дүн	3,540,861,508.05	457,592,869.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,915,743,793.73	2,915,743,793.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,540,861,508.05</b>	<b>3,998,454,377.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,088,111,337.60</b>	<b>2,981,918,768.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>57,302,967.60</b>	<b>397,076,168.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>57,302,976.60</b>	<b>397,076,168.80</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>45,755,150.00</b>	<b>16,292,098.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,793,400.00	9,922,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,873,750.00	6,370,098.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,088,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,567,357.60	347,126,018.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	980,460.00	33,658,052.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,030,808,370.00</b>	<b>2,584,807,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,935,213,700.00</b>	<b>2,529,256,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,935,213,700.00	2,529,256,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,935,213,700.00	2,529,256,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>95,594,670.00</b>	<b>55,551,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,594,670.00	55,551,300.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,094,823,699.95</b>	<b>2,524,325,899.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,094,823,699.95</b>	<b>2,524,325,899.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,919,713,141.95</b>	<b>2,358,819,852.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,439,774,072.00</b>	<b>1,755,355,071.35</b>
210101	Үндсэн цалин	969,378,640.00	1,156,710,507.35
210102	Нэмэгдэл	378,155,759.00	525,294,598.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	333,000.00
210104	Урамшуулал	65,948,473.00	73,016,966.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,291,200.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>179,345,700.00</b>	<b>231,731,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	121,315,200.00	156,200,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,507,600.00	16,866,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,606,200.00	17,121,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,901,300.00	4,059,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,015,400.00	37,482,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,949,992.00</b>	<b>48,744,792.72</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,079,270.00	16,859,669.47
210302	Түлш, халаалт	26,012,586.00	27,664,057.78
210303	Цэвэр, бохир ус	3,858,136.00	4,221,065.47
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,034,590.00</b>	<b>34,956,868.00</b>
210401	Бичиг хэрэг	4,484,250.00	4,795,048.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,594,150.00	1,722,075.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,956,190.00	28,439,745.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>490,550.00</b>	<b>1,195,270.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	430,550.00	1,195,270.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,684,780.00</b>	<b>27,830,797.00</b>
210604	Урсгал засвар	12,684,780.00	27,830,797.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,605,782.00</b>	<b>13,467,168.55</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,960,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,645,382.00	13,467,168.55
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>206,827,675.95</b>	<b>245,538,684.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,332,219.00	27,928,462.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,239,745.77	32,937,899.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,255,711.18	184,672,323.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>175,110,558.00</b>	<b>165,506,047.28</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>165,526,200.00</b>	<b>164,368,840.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	142,767,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	145,284,100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,242,100.00	21,601,840.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,584,358.00	1,137,207.28
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,137,207.28</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,137,207.28
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(6,712,362.35)</b>	<b>457,592,869.20</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>(10,182,344.37)</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	10,182,344.37	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(16,894,706.72)</b>	<b>457,592,869.20</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,052,825,520.00</b>	<b>2,601,099,698.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,667,150.00</b>	<b>16,292,098.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>17,667,150.00</b>	<b>16,292,098.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>17,667,150.00</b>	<b>16,292,098.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,793,400.00	10,447,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,873,750.00	5,845,098.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,035,158,370.00</b>	<b>2,584,807,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,935,213,700.00</b>	<b>2,529,256,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,935,213,700.00	2,529,256,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,350,000.00</b>	<b>0.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,350,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>95,594,670.00</b>	<b>55,551,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	95,594,670.00	55,551,300.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,935,995,543.00</b>	<b>2,310,237,969.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,935,995,543.00</b>	<b>2,310,237,969.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,760,884,985.00</b>	<b>2,144,731,922.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,439,774,072.00</b>	<b>1,755,355,071.35</b>
210101	Үндсэн цалин	969,378,640.00	1,156,710,507.35
210102	Нэмэгдэл	378,155,759.00	525,294,598.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	333,000.00

210104	Урамшуулал	65,948,473.00	73,016,966.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,291,200.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>179,345,700.00</b>	<b>231,731,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	121,315,200.00	156,200,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,507,600.00	18,882,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,606,200.00	15,106,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,901,300.00	3,776,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,015,400.00	37,765,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,949,992.00</b>	<b>48,744,792.72</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,079,270.00	16,859,669.47
210302	Түлш, халаалт	26,012,586.00	27,664,057.78
210303	Цэвэр, бохир ус	3,858,136.00	4,221,065.47
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,000,000.00</b>	<b>10,080,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	580,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	9,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,476,782.00</b>	<b>15,891,568.55</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,943,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,533,382.00	15,891,568.55
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,338,439.00</b>	<b>82,929,290.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,632,139.00	57,851,842.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,706,300.00	25,077,448.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>175,110,558.00</b>	<b>165,506,047.28</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>165,526,200.00</b>	<b>164,368,840.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	145,284,100.00	142,767,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,242,100.00	21,601,840.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>9,584,358.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,584,358.00	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,137,207.28</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,137,207.28
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>116,829,977.00</b>	<b>290,861,728.10</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>88,087,760.00</b>	<b>65,134,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>88,087,760.00</b>	<b>65,134,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>88,087,760.00</b>	<b>65,134,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,087,760.00	65,134,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(88,087,760.00)</b>	<b>(65,134,800.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>28,742,217.00</b>	<b>225,726,928.10</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	28,742,217.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,742,217.00	254,469,145.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,543,556,279.24	2,915,743,793.73	(4,459,300,072.97)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(4,459,300,072.97)	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,540,861,508.05	3,540,861,508.05
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(918,438,564.92)	3,540,861,508.05
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(918,438,564.92)	3,540,861,508.05
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(918,438,564.92)	3,540,861,508.05
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	457,592,869.20	457,592,869.20
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,556,279.24	2,915,743,793.73	(460,845,695.72)	3,998,454,377.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,648,885,900.00</b>	<b>2,374,235,562.62</b>	<b>(274,650,337.38)</b>	<b>89.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,648,885,900.00</b>	<b>2,374,235,562.62</b>	<b>(274,650,337.38)</b>	<b>89.6</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,455,018,900.00</b>	<b>2,209,866,722.62</b>	<b>(245,152,177.38)</b>	<b>90.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,955,153,200.00</b>	<b>1,755,355,071.35</b>	<b>(199,798,128.65)</b>	<b>89.8</b>
210101	Үндсэн цалин	1,328,033,800.00	1,156,710,507.35	(171,323,292.65)	87.1
210102	Нэмэгдэл	549,226,200.00	525,294,598.00	(23,931,602.00)	95.6
210104	Урамшуулал	77,893,200.00	73,016,966.00	(4,876,234.00)	93.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>244,394,000.00</b>	<b>231,731,200.00</b>	<b>(12,662,800.00)</b>	<b>94.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	166,187,900.00	156,200,900.00	(9,987,000.00)	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	19,551,500.00	18,882,400.00	(669,100.00)	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,641,200.00	15,106,200.00	(535,000.00)	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,910,300.00	3,776,500.00	(133,800.00)	96.6
210205	Эрүүл мэндийн даатгал	39,103,100.00	37,765,200.00	(1,337,900.00)	96.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,134,600.00</b>	<b>48,744,792.72</b>	<b>(18,389,807.28)</b>	<b>72.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,742,100.00	16,859,669.47	(4,882,430.53)	77.5
210302	Түлш, халаалт	39,482,400.00	27,664,057.78	(11,818,342.22)	70.1
210303	Цэвэр, бохир ус	5,910,100.00	4,221,065.47	(1,689,034.53)	71.4
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,240,000.00</b>	<b>10,240,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	740,000.00	740,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	9,500,000.00	9,500,000.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,617,900.00</b>	<b>15,891,568.55</b>	<b>(726,331.45)</b>	<b>95.6</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,617,900.00	15,891,568.55	(726,331.45)	95.6
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>161,479,200.00</b>	<b>147,904,090.00</b>	<b>(13,575,110.00)</b>	<b>91.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,401,700.00	122,826,642.00	(13,575,058.00)	90.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,077,500.00	25,077,448.00	(52.00)	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,867,000.00</b>	<b>164,368,840.00</b>	<b>(29,498,160.00)</b>	<b>84.8</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>193,867,000.00</b>	<b>164,368,840.00</b>	<b>(29,498,160.00)</b>	<b>84.8</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	172,263,800.00	142,767,000.00	(29,496,800.00)	82.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,603,200.00	21,601,840.00	(1,360.00)	100.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,648,885,900.00</b>	<b>2,599,962,490.72</b>	<b>(48,923,409.28)</b>	<b>98.15</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,529,256,300.00</b>	<b>2,529,256,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,529,256,300.00	2,529,256,300.00	0.00	100.0
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>73,134,600.00</b>	<b>54,414,092.72</b>	<b>(18,720,507.28)</b>	<b>74.4</b>
320001	Орон нутгийн төсвөөс	73,134,600.00	54,414,092.72	(18,720,507.28)	74.4
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>46,495,000.00</b>	<b>16,292,098.00</b>	<b>(30,202,902.00)</b>	<b>35.0</b>

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,527,000.00	9,922,000.00	(2,605,000.00)	79.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,225,700.00	6,370,098.00	1,144,398.00	121.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,742,300.00	0.00	(28,742,300.00)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		28,742,217.00	28,742,217.00	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		254,469,145.10	254,469,145.10	0.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>89.00</b>	<b>89.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	76.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	0.00	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	1,281.00	1,338.00	57.00	104.4

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,720.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 59,504.8 мянган төгрөгийн 3 алдааг удитын явцад залруулж, 86.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,128.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөрчилд зөвлөмж өглөө.

2023 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан 378.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүнг 16,894.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийг 42,231.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон, нийт 64,720.0 мянган төгрөгийн алдаатай тайлагнасныг УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

### 3.1 Төлбөрийн акт

1. Ажилтанд хавсран ажилласны нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээнээс илүү тооцож 86.8 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна .

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодогч Ц.Дэлгэрмаа, нярав Д.Эрдэнэцэцэг нарт БШУЯ-ны 2/3151 тоот албан бичгийг үндэслэн захирлын 2023 оны 07 сарын 04-ны өдрийн А/26 тоот тушаалаар 1,982.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 4.8.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно, улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тооцох урамшууллын хэмжээг энэ журмын 4.5-д заасан аргачлалд тусгана” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 2. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын 2023 оны бүтэц, орон тоонд батлагдаагүй ажлын байран дээр хавсран, орлон гүйцэтгэх тушаалаар үндсэн ажилтан нарт 1,396.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай 56 дугаар зүйлийн 56.1 - т "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно, 56.2-т тухайн ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайлан, орлого зарлагыг түүвэрлэн шалгахад аж ахуйн материалын /35420/ тоот дансанд барилгын 13 нэр төрлийн 1,694.5 мянган төгрөгийн барилгын материалыг орлогоор, бичиг хэргийн материалын 35410 тоот данснаас 55.5 мянган төгрөгийн бичгийн цаасыг засварын зардлаар бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4.16 “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө” заалтуудыг зөрчсөн ба “Үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Бараа материалыг зөв ангилан бүртгэж байх зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан зөрүүтэй илэрхийлсэн	1	378.5					1	378.5				
Санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн тайлан ирүүлсэн	1	16,894.7					1	16,894.7				
2023 оны үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцоолсон.	1	42,231.6					1	42,231.6				
	3	59504.8	0	0	0	0	3	59504.8	0	0	0	0

##### Санхүүгийн тайлангийн аудитын ы нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын ангилал зөв бүртгэх.	1	1,750.0					1	1,750.0				

Бүтэц орон тоонд тусгагдаагүй ажлын байран дээр хавсран, орлон гүйцэтгэх тушаалаар үндсэн ажилтан нарт нэмэгдэл цалин олгосон	1	1,396.4					1	1,396.4				
Цалингийн тооцоолол, олгох хувь хэмжээг хянаагүйгээс нэмэгдэл цалин илүү олгосон.	1	86.8	1	86.8								
Балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан цалингийн сангаас олгосон	1	1,982.0					1	1,982.0				
Дүн	4	5,215.2	1	86.8	0	0	3	5,128.4	0	0	0	0